

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ Д.ГҮН-ҮЙЛС, Ч.БАТЦЭНГЭЛ,
Ж.БИЛЭГСАЙХАН, Д.МЯГМАРСҮРЭН, Д.НАРАНЦЭЦЭГ, С.ОД-ЭРДЭНЭ,
М.ТӨРМАНЛАЙ, Г.ЭНХБАЯР, Л.ЭНХЖИН, Б.ЭНЭРЭЛТ НАРТАЙ ХИЙСЭН
НЭР ДЭВШИГЧИЙН СОНСГОЛЫН ТАЙЛАН**

***Товч удирдамж:** Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал
Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:
<p>Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсэгт заасны дагуу Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр хэлэлцэж томилохоор заасан.</p> <p>Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэгт “Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид; эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд; эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно.” гэж, 21.7 дахь хэсэгт “... төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж, 21.8 дахь хэсэгт “... нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.</p> <p>1/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Дугарсүрэн овогтой Гүн-Үйлс /Төрт ёс хаадын сан ТББ/, Монгол Улсын Засгийн газраас нэр дэвшүүлсэн Чулуунбаатар овогтой Батцэнгэл /Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим/, Улсын Их Хурлаас нэр дэвшүүлсэн Эрдэнэбилэг овогтой Адъяасүрэн /Тэтгэврийн реформ хөдөлгөөн НҮТББ/, Жанчивдорж овогтой Билэгсайхан /Монголын гольфийн холбоо НҮТББ/, Дашзэвгэ овогтой Мягмарсүрэн /Монголын олон нийтийн харилцааны мэргэжилтний холбоо ГҮТББ/, Дагвадорж овогтой Наранцэцэг /Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо/, Сандаг овогтой Од-Эрдэнэ /Соёл, спорт боловсролын хөтөч НҮТББ/, Маналжав овогтой Төрманлай /Нийгмийн хөгжлийн гарц НҮТББ/, Гүнчин-Иш овогтой Энхбаяр /Монголын багш нарын холбоо НҮТББ/, Луна овогтой Энхжин /Монгол гайхамшиг төв НҮТББ/, Батболд овогтой Энэрэлт /Монголын боловсролын реформ хөдөлгөөн НҮТББ/ нар нь Төрийн</p>

байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж Байнгын хороонд ирүүлсэн болно.

Монгол Улсын Их Хурлаас Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхээр санал болгосон нэр дэвшигчдийн нэг болох Эрдэнэбилэгийн Адъяасүрэн нь өөрийн хүсэлтээр нэрээ татсан болно.

2/Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 13 дугаар тогтоолоор Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг төрийн бус байгууллагуудын саналаас сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатараар ахлуулан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, А.Ганбаатар, Ц.Идэрбат, Ч.Лодойсамбуу, Г.Уянгахишиг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан шаардлага болох эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаас тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг Улсын Их Хурлаас нэр дэвшүүлэх тухай зохицуулалт, холбогдох шаардлагыг үндэслэн нэр дэвшигчдийн ирүүлсэн материал шаардлага хангаж байгаа эсэхийг хянан үзэж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Улсын Их Хурлын гишүүдийн сонгох эрхийг хангах үүднээс Төрийн байгуулалтын байнгын хороонд 9 нэр дэвшигчийг санал болгож, нэр дэвшигчийн сонсголд оролцуулахаар хүргүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо нэр дэвшигчтэй хийх томилгооны сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд зохион байгуулахаар тов тогтоосны дагуу сонсголыг зохион байгуулсан.

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:

- Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулсан.
- Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас parliament.mn болон бусад сайтуудад 14 хоногийн хугацаанд давтамжтай байршуулж, оролцогч, ажиглагчийг бүртгэсэн.
- Зарын дагуу сонсголд оролцохоор 2 оролцогч бүртгүүлж асуулт ирүүлсэн болно.

4/2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Төрийн байгуулалтын байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Ж.Баярмаа, Э.Болормаа, С.Бямбацогт, А.Ганбаатар, Ц.Даваасүрэн, С.Зулпхар, Л.Мөнхбаатар, Б.Найдалаа, Н.Номтойбаяр, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ч.Ундрам, Н.Учрал, Б.Хэрлэн, Ө.Шижир, Б.Энхбаяр, Д.Энхтуяа нар буюу Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан болно.

5/Нэр дэвшигч Д.Гүн-Үйлс, Ч.Батцэнгэл, Ж.Билэгсайхан, Д.Мягмарсүрэн, Д.Наранцэцэг, С.Од-Эрдэнэ, М.Төрманлай, Г.Энхбаяр, Л.Энхжин, Б.Энэрэлт нар Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвших болсон үндэслэл, эзэмшсэн боловсрол, ажлын туршлагаа танилцуулсан бөгөөд ажлын хэсгийн тайлан, нэр дэвшигчийн танилцуулгыг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг төрийн бус байгууллагуудын саналаас сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн **Б.Баярбаатар** танилцуулсан.

6/Нэр дэвшигч нар Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвших болсон үндэслэл, сонгогдсон тохиолдолд хийх ажлын талаар:

Д.Гүн-Үйлс нэр дэвшигч:

Миний бие үндэсний түүх, өв соёл, утга зохиолын салбарт олон жил ажиллаж, Монголынхоо ирээдүй хойч үе болон ард түмнийг соён гэгээрүүлэх үйлсэд өөрийн мэдлэг чадвараа зориулж ирсэн билээ. МҮОНРТ-ийн Үндэсний Зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлж буй гол үндэслэл нь тус байгууллагыг үндэсний нэгдмэл үнэт зүйл, эв нэгдэл, соёл гэгээрлийн гол цөм байлгахад өөрийн мэргэжлийн туршлага, иргэний байр суурийг зориулах эрмэлзэл юм. Өнөөдөр нийгэмд талцал хуваагдал ихсэж, үл ойлголцол газар авч буй энэ үед үндэсний телевиз, радио нь ард түмнийг соён гэгээрүүлэх, эв нэгдлийг хангах "гүүр" болох ёстой. Би вээр зохиолч, түүх соёлоо эрхэмлэгч хүний хувьд энэхүү үйл хэрэгт бодлогын болон агуулгын бодит хувь нэмэр оруулж чадна гэдэгтээ итгэлтэй байна. МҮОНРТ-ийн Үндэсний Зөвлөлийн гишүүний чиг үүргийн хүрээнд дараах чиглэлүүдийг нэн тэргүүний зорилт болгон ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

- Түүх соёлын чиглэлээр бэлтгэж буй контентын агуулгын үнэн зөв байдал, оюуны үнэ цэнийг хамгаалахад анхаарна. Хуурамч болон туйлширсан түүхэн тайлбараас ангид байж, үндэсний ой санамжийг зөвөөр төлөвшүүлэхэд чиглэсэн контентын бодлогыг дэмжинэ. Түүхийг зөвхөн дурсах биш, ирээдүйн хөгжлийн хөдөлгүүр болгох агуулгын шинэчлэлд анхаарна.
- Олон нийтийн радио, телевизийн мэдээ, мэдээллийн хөтөлбөрүүд нь тэнцвэртэй, үнэн зөв, ёс зүйтэй байх зарчмыг баримталж, нийгмийн сэтгэл зүйг тогтвортой байлгахад чиглэсэн хариуцлагатай сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Олон нийтийн радио, телевиз нь нийгмийг талцуулах бус, нэгтгэх үүрэгтэй. Гэр бүлийн үнэт зүйл, хөршийн холбоо, нийгмийн эерэг хандлагыг сурталчилсан нэвтрүүлгүүдийг нэмэгдүүлж, стрессгүй, ёс зүйтэй мэдээллийн орчныг бүрдүүлэхэд хяналт тавина.
- Монголын түүх, соёлын гайхамшгийг дэлхий дахинд таниулах гадаад сурталчилгааны бодлогыг чанаржуулах, 'Монгол контент'-ийг олон улсын стандартад нийцүүлэн экспортлох боломжийг эрэлхийлэхэд зөвлөнө.

Би вээр МҮОНРТ-ийг зөвхөн мэдээллийн хэрэгсэл биш, монгол хүний оюун санааны тусгаар тогтнолын нэгэн баталгаа гэж хардаг. Миний зорилго бол эфирийн цаг бүрийг үзэгчиддээ шинэ мэдээлэл хүргэх, ард түмнийг соён гэгээрүүлэх, эх орноо хайрлах үзлээр цэнэглэхэд чиглүүлэх юм. Түүхээ мэддэг, эх хэлээ дээдэлдэг, эв

нэгдэлтэй үндэстнийг бүтээхэд МҮОНРТ-ийн үүрэг маш их. МҮОНРТ-ийг Монголын ард түмний оюун санааны нэгдмэл дархлааг хамгаалагч, жинхэнэ утгаараа "Олон нийтийн" байгууллага байлгахын төлөө хичээн ажиллах болно.

Ч.Батцэнгэл нэр дэвшигч:

Миний бие МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнд эдийн засгийн чиглэлээр нэр дэвшиж байгаа нь олон нийтийн радио, телевизийн санхүү, эдийн засгийн тогтвортой байдал, үр ашигтай менежментийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой юм. Олон нийтийн мэдээллийн байгууллага нь нийгмийн оюуны дархлаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдолтой учир түүний санхүүгийн бодлого, нөөцийн оновчтой удирдлага нь үйл ажиллагааны чанарт шууд нөлөөлдөг гэж үзэж байна. Хэрэв энэхүү албан тушаалд томилогдвол дараах үндсэн чиглэлд анхаарч ажиллана.

- Санхүүгийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулахад анхаарна. Байгууллагын төсөв, санхүүгийн зарцуулалт нь олон нийтэд нээлттэй, ойлгомжтой, хяналттай байх ёстой. Иймд төсөв төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын уялдаа холбоог сайжруулж, аудит, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр бодлогын түвшинд дэмжин ажиллана.
- Орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг дэмжинэ. Олон нийтийн байгууллагын санхүүжилт нь зөвхөн нэг эх үүсвэрээс хамаарах бус, олон талт, эрсдэлд тэсвэртэй байх шаардлагатай. Иймд хууль, журмын хүрээнд зар сурталчилгаа, хамтын ажиллагаа, контент борлуулалт, дижитал платформын орлого зэрэг эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судалж, бодлогын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ.
- Зардлын үр ашгийг дээшлүүлэх, нөөцийн оновчтой хуваарилалтыг бий болгоход анхаарна. Байгууллагын үйл ажиллагаанд үр ашиггүй зардлыг бууруулах, давхардлыг арилгах, хөрөнгө оруулалтыг стратегийн ач холбогдол бүхий чиглэлд төвлөрүүлэх нь чухал. Энэ хүрээнд дата, тоон шинжилгээнд суурилсан шийдвэр гаргалтыг нэвтрүүлэхийг дэмжиж ажиллана.
- Дижитал шилжилтийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарна. Орчин үеийн медиа орчинд цахим платформ, контент түгээлтийн шинэ хэлбэрүүд нь орлогын шинэ боломжийг бий болгож байна. Иймд технологийн шинэчлэл, дижитал хөрөнгө оруулалтыг эдийн засгийн үр ашигтай уялдуулах бодлогыг дэмжин, урт хугацаанд өгөөжтэй шийдлүүдийг хэрэгжүүлэхэд анхаарна.
- Эрсдэлийн удирдлага, санхүүгийн сахилга батыг бэхжүүлэхэд анхаарна. Макро эдийн засгийн нөхцөл байдал, зах зээлийн хэлбэлзэл, санхүүжилтийн өөрчлөлт зэрэг эрсдэлийг урьдчилан тооцоолж, зохих хариу арга хэмжээг бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх нь чухал гэж үзэж байна.

Миний хувьд эдийн засаг, санхүү, удирдлагын чиглэлээр хуримтлуулсан мэдлэг, туршлагадаа тулгуурлан МҮОНРТ-ийн санхүүгийн тогтвортой байдал, үр ашигтай менежментийг сайжруулахад бодит хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна. Мөн бодлого боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад оролцох чадвар нь Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд үр өгөөжөө өгнө гэдэгт итгэлтэй байна. Иймд МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр ажиллахдаа санхүүгийн

ил тод байдал, эдийн засгийн тогтвортой байдал, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг бэхжүүлж, байгууллагын урт хугацааны хөгжлийг дэмжихэд чиглэсэн бодлогын шийдвэрүүдийг дэмжин ажиллах болно. Энэ нь олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, байгууллагын хараат бус байдлыг баталгаажуулах, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх чухал суурь болно гэж үзэж байна.

Ж.Билэгсайхан нэр дэвшигч:

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хүрээнд олон нийтийн эрх ашгийг дээдэлсэн, хараат бус, үнэн бодит мэдээлэл түгээх, боловсрол, танин мэдэхүй, соён гэгээрүүлэх, үндэсний нэгдмэл байдлыг бэхжүүлэх үйл ажиллагаа явуулах нь энэхүү байгууллагын үндсэн зорилго юм. Хэрэв миний бие энэхүү албан тушаалд томилогдвол дараах ажлуудыг хэрэгжүүлж ажиллана.

- Олон нийтийн радио, телевизийн хараат бус байдал, редакцийн бие даасан байдлыг бодит байдал дээр хэрэгжүүлэхэд анхаарна. Үүнд улс төр, бизнесийн аливаа нөлөөллөөс ангид байлгах, редакцийн ажилтнууд өөрсдийн мэргэжлийн ёс зүйд тулгуурлан чөлөөтэй контент бүтээх орчин бүрдүүлнэ.
- Үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлгийг орчин үеийн техник технологид тулгуурлан шинэчилж, хөдөө орон нутгийн иргэдийг чанартай мэдээллээр хангах, тэгш хүртээмжийг сайжруулахад анхаарна. Мөн залуус, хүүхэд, ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан контентын төрөлжилтийг нэмэгдүүлнэ мөн залуус, хүүхэд багачуудын бие бялдарын хөгжил, спортын тэгш хүртээмжийн талаарх хөтөлбөрүүдийг дэмжиж, хөдөө орон нутгийн иргэдэд зориулсан контентын хүртээмжийг сайжруулахад онцгойлон анхаарна.
- Монгол Улсыг дэлхий дахинд таниулах, эх орныхоо үнэт зүйлсийг сурталчлах гадаад хэлээрх нэвтрүүлгийн чанар, хүртээмжийг сайжруулна. Үүний тулд олон улсын медиа хамтын ажиллагааг өргөжүүлж, контентын экспортын боломжийг судлан хэрэгжүүлнэ.

Миний спортын салбарт ажилласан бодит туршлага, олон нийттэй ажиллах чадвар, төслийн менежментийн мэдлэг маань Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааг илүү хүртээмжтэй, нийгэмд ойр, бодлого хандлагатай байхад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Мөн манлайлан ажиллах чадвар, нийгмийн хариуцлагатай байгууллага удирдаж байсан туршлага маань энэхүү үүргийг нэр төртэй гүйцэтгэх суурь болно гэж үзэж байна. Миний бодлоор олон нийтийн радио, телевиз бол ард түмний дуу хоолой, нийгмийн толь бөгөөд энэхүү эрхэм байгууллагын үйл ажиллагааг ил тод, шударга, тэнцвэртэй байлгаж чадвал Монгол Улсын ардчилал, үндэсний хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна. Тиймээс энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд бүх хүч, мэдлэг, чадвараа зориулан ажиллах чин эрмэлзэлтэй байна.

Д.Мягмарсүрэн нэр дэвшигч:

Аливаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бол нийгмийг соён гэгээрүүлэх, мэдээ мэдээллээр хангах, зугаацуулах, танин мэдүүлэх зэрэг олон чиг үүргийг нийгэмд гүйцэтгэдэг. Орчин үед ОНМХ-ийн энэхүү үүргүүдийг нэр төртэйгөөр гүйцэтгэж буй гол институцийн нэг бол МҮОНРТ бөгөөд монгол хэлний яруу илэрхийлэл, мэдээллийг олон нийтэд хүргэх сонгомол хэв маягийг Монголд бий

болгон хөгжүүлж, улмаар бусад ОНМХ-ийн хувьд үлгэр дуурайл болж, олон чадварлаг боловсон хүчин энэхүү байгууллагад бэлтгэгдэж ирсэн байдаг. Үндэсний радио, телевизийн мэдээлэл, нэвтрүүлэг бэлдэх, сурвалжлах, редакц хийх, нэвтрүүлэх, хөтлөх, түгээх үйл явц нь тус салбарын хувьд соёл хандлагын хувьд зөв жишиг болж ирсэн. Цаашид ч тийм байх учиртай. Тэрчлэн мэдээллийн хэрэгслийн соён гэгээрүүлэх, зугаацуулах, танин мэдүүлэх үүргийг аль болох тэнцвэртэй хангах чиглэлээр бодлого, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж ирсэн. Энэхүү сэтгүүл зүйн үнэт өв соёл, арга барилыг хэвшүүлэн үлдээх, хадгалахад зөвлөлийн гишүүний хувьд дэмжлэг үзүүлж ажиллана.

Нөгөө талаас МҮОНРТ нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мэдээллийн хамгийн том, хүртээмжтэй суваг бөгөөд хүн ардыг олон улсын түвшинд болон дотоодод өрнөж буй улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явдлын талаар тэгш, төвийг сахисан мэдээллээр хангах үүрэг хүлээдэг. Энэ утгаар мэдлэг, мэдээллийн чухал эх сурвалж болж, нийгмийн оюун санааны хэрэгцээг хангаж байдгийн хувьд мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой үндэсний аюулгүй байдлын чухал бүрдэл болж байдаг. МҮОНРТ нь үндэсний оюун санааны дархлааг хамгаалах манааны хамгийн том төлөөлөл, суваг болохын хувьд түүний бие даасан байдал, гадаад, дотоод нөлөөллөөс ангид байх явдал нь үндэсний аюулгүй байдалтай шууд холбогддог. Иймд үндэсний мэдээллийн дархлаат байдлыг хангах, хамгаалахад зөвлөлийн гишүүний хувьд хяналт тавьж, холбогдох хууль дүрэм, бодлогын шаардлага нөхцөлийг мөрдүүлэхэд анхаарна.

Аливаа байгууллага тэр дундаа хэвлэл мэдээллийн байгууллагын нэр хүнд нь бие даасан бодлого, үйл ажиллагаа, мэргэшсэн байдлаас байхаас шууд хамаардаг. Сүүлийн үед МҮОНРТ нь иргэдийн татвар, албан журмын төлбөрөөр санхүүждэг хэр нь олон нийтийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй, улс төрийн нөлөөлөлд автдаг, гадаадын аль нэг улс орны мэдээллийг түлхүү өгдөг, бэлтгэсэн мэдээ мэдээлэл, нэвтрүүлэг контентын чанар чансаа сул зэрэг янз бүрийн шүүмжлэл дагуулах болсон тал бий. Иргэд, олон нийтээс ирж буй энэхүү хүсэлт шаардлагыг сонсож, нийтлэл нэвтрүүлгийн бодлого, үйл ажиллагаанд анхаарч, шинэчлэл өөрчлөлт хийх хэрэгцээ байна гэж үзэж байна. Мэдээж аливаа байгууллагад байнгын тулгардаг асуудал, сорилт бэрхшээл бий. Үүнийг олон нийтэд зөвөөр ойлгуулж, үзэгч сонсогч буюу хэрэглэгчидтэй хамтран ойлголцож, түншилж байж энэхүү асуудлаа шийдвэрлэх, дараагийн түвшинд ахих ёстой. Олон нийттэй харилцах орчин үеийн коммуникацийн үзэл баримтлал, загварыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх хэрэгцээ аль хэдийн үүссэн гэж болно. Өөрөөр хэлбэл, хоёр талт тэгш бус хэмт (two way asymmetrical model) харилцааны загвараас тэгш хэмт (two way symmetrical model) харилцааны загварыг олон нийттэй харилцах үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай байна. Иймд МҮОНРТ-ийн олон нийтийн харилцааны үйл явцыг шинэчлэх, байгууллагын нэр хүндийг өсгөх чиглэлээр бодлого стратеги, ажлын арга барилыг шинэчлэх чиглэлээр мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажиллана.

МҮОНРТ нь хүний нөөц, контент, нэвтрүүлэг бэлтгэх арга барил, техник сүлжээний уламжлалт бааз суурь сайтай ч өдгөө бусад ОНМХ-үүдтэй харьцуулахад хоцрогдох талууд ажиглагдаж эхэлсэн. Ялангуяа техник, технологийн хувьд орчин үеийн мэдээллийн технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, бусад хэвлэл мэдээллийн хандалт ихтэй контенттэй өрсөлдөхүйц нэвтрүүлэг, бүтээл гаргах шаардлага хэрэгцээ байна хэмээн үзэж байна. Ялангуяа нийгмийн сүлжээг давхар ашиглан мэдээ, мэдээллээ түгээх, иргэний сэтгүүл зүйн орчин үеийн арга барил, нөлөөллийн маркетингийн хэлбэрүүдийг шингээсэн контент бүтээхэд редакцийн бодлого, үйл

ажиллагааг чиглүүлэх ажлыг өргөжүүлэх хэрэгтэй байгаа. Иймд тус байгууллагын техник, технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ орчин үеийн контент бүтээх концепцийг нэвтрүүлэхэд туршлагаа хуваалцаж, холбогдох эрх барих байгууллагад дуу хоолойг хүргэх, төсөв санхүүгийн хувьд бэхжүүлэхэд анхаарал хандуулж ажиллана.

Д.Наранцэцэг нэр дэвшигч:

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн шинэчлэлийг даруй хийх. Үндэслэл нь 21 жил даган мөрдөж, туршигдсан тухайн хуулинд сайжруулж засах заалтууд мөн шинээр эрх болон үүргийн тухай оруулах шаардлага бий. Хураамжийг шинэчлэх, өв соёлын дархлааг энэ хуулиар дамжуулан хадгалах хамгаалах зохицуулалтыг хийх, төсвийн дэмжлэгийг тогтмол болгох, зар сурталчилгааг зах зээлийн хэлбэрт оруулах, ҮЗ-ийн гишүүдийн томилгоонд өөрчлөлт оруулна.

Уран бүтээлчид инженер техникийн ажилтан, ажиллагсдын нийгмийн асуудлыг оновчтойгоор шийдвэрлүүлэх, уран бүтээлийн болон үл хөдлөхийн менежментийг зөв боловсруулснаар байгууллагын санхүүгийн чадвар сайжрах бүрэн боломжтой ингэснээр үндсэн болон дэмжих салбарын ажиллагсдын амьдралын чанарт сайн нөлөө үзүүлнэ.

Монгол улсын түүхийн цаг тооны бичвэр- өдөр бүрийн мэдээ нэвтрүүлэг - архивыг сайжруулах үнэт өв болгоно.

Нүүдэлчин өв соёлын залгамж чанарыг сайжруулахын тухайд уран бүтээлчдийн томилолт уран бүтээлийн зардлыг төсөл хөтөлбөрийн чиглэлээр санхүүжилт босгоно.

Зөөлөн хүчний бодлогоор олон ангит кино болон соёл өв уламжлал байгал аялал жуулчлалын нэвтрүүлгүүдийголон улсын стандартаар бэлтгүүлж хөтөлбөр солилцоонд оруулах боломж бололцоог гүйцэтгэх удирдлагуудад санал болгон жил бүр бодлого, санхүүгээр дэмжинэ.

Орчин цагийн ТВ радиогийн шинэ техник инновацийг нэвтрүүлэх, ашиглахад түүчээлэн оролцох ингэснээр уран бүтээл болон уран бүтээлчид чанаржих,

Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг сурталчлах үүрэг бүхий байгууллага байх ёстой. “Үндэсний” гэсэн тодотголтой хэвлэл мэдээллийн байгууллагын нэгэн чухал зорилго бол үндэсний ухамсрыг сэрээх, олон нийтийн сайн мэддэггүй бахархалт соёлын өвийг танин мэдүүлж сурталчлах ажил юм. “Үндэсний” гэсэн тодотголтой хэвлэл мэдээллийн байгууллагын нэгэн чухал үүрэг бол бүх тохиолдолд “Монгол хэлний тухай хуульд” заасны дагуу утга зохиолын хэлний хэм хэмжээг ягштал мөрдөх явдал юм. Хэрвээ сонгогдвол Хүн төвтэй Үндэсний хэмжээний уран бүтээлийн байгууллага болгохын төлөө зорин ажиллана. ОУ-ын хэмжээний ижил төстэй байгууллагуудын жишигт хүрсэн Олон нийтийн ҮНДЭСНИЙ РАДИО ТЕЛЕВИЗ гэсэн эрхэм хүндлэлийг бий болгохын төлөө ажиллах болно.

Дэвших үндэслэл: 2005 онд батлагдан хэрэгжиж эхэлсэн ОНРТ-ийн тухай хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, сайныг дэмжиж, саарыг хэлж ярьж ойлгуулахыг хичээсээр иржээ. Сайн санааны эвлэлдэн нэгдэх байгууллага Үйлдвэрчний эвлэлийн анхан шатны салбараас удирдах хүртэл 22 жил энэ ТББ-д хамааралтай явсан байна. МҮОНРТ-д зориулсан хуулийн хэрэгжилтээс харахад хүндээ бус

хуулиндаа өөрчлөлт оруулах шаардлагатайг практик нотолдог. Гэхдээ 2021 оноос хойш хуулийн тодорхой нэмэлт өөрчлөлтийг хийх боломж олон бсан боловч хийхгүйгээр өнөөдөр хүрлээ. Энэ олон нийтийн байгууллага улс оронд зайлшгүй байх хэрэгтэй. Олон нийтийн хураамж, төсвийн дэмжлэг, хандив, төсөл хөтөлбөр, зар сурталчилгаа зэргээр санхүүжин, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэгтэй. 21 аймаг 300 сумын аж амьдрал, хандлага, хөгжил цэцэглэлтийг дурандаа буулгасаар байх ёстой. Уул ус, гол мөрөн, ай сав газар, ан амьтан, ургамал ногоог байгаагаар нь буулган үлдээх ёстой түүхэн процесс тасралтгүй явагдах ёстой. Улам илүү, улам сайн болгохын төлөө нэрээ дэвшүүлж байна. Дээрх түүхэн зураглалаас гадна хүний нийгэм хүнийхээ төлөө байх хэрэгтэй. Нийгэм бол хүн. Нийгэм хамгаалал бол хүн хамгаалал. Би энэ салбарыг төлөөлөн 22 жил ажилласандаа сэтгэл хангалуун байдаг.

С.Од-Эрдэнэ нэр дэвшигч:

Хөдөө орон нутагт олон арван жилийн турш иргэд, малчид, залуучууд, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, амьдарч ирсэн туршлагатай. Энэ хугацаанд аймгийн боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулах, элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг сайжруулах, математикийн олимпиад болон хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд биечлэн оролцож, боловсрол, соёл, спортын салбарын хөгжилд бодит хувь нэмэр оруулсан.

Дэлхий нийтээр оюуны өмч, зохиогчийн эрхийг эрхэмлэн хамгаалж буй өнөө үед уран бүтээлчдийн эрх ашгийг хамгаалах, тэдний бүтээлийг хойч үед өвлүүлэн үлдээх, үндэсний ахуй соёл, өв уламжлалыг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх асуудалд онцгой анхаарч ажиллаж ирсэн. Энэ хүрээнд зохиогчийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад зөвлөмж өгч, хамтран ажиллахын зэрэгцээ Улаан загалмай болон аймаг, сумдын нутгийн зөвлөлийн үйл ажиллагаанд оролцож, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр туршлага хуримтлуулсан. Миний хуримтлуулсан мэдлэг, туршлага нь Монголын ард түмэнд үйлчлэх олон нийтийн радио, телевизийн зорилго, үйл ажиллагааны зарчим, хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход орон нутгийн иргэдийн дуу хоолой, төлөөлөл болж ажиллах хүсэл эрмэлзэл, итгэл үнэмшлийн үндэс болсон.

Үндэсний хэмжээний өргөн нэвтрүүлгийн байгууллагын хувьд Олон нийтийн радио, телевиз нь иргэдэд үнэн зөв мэдээлэл хүргэхээс гадна Монгол Улсын түүх, соёл, өв уламжлал, нүүдлийн иргэншлийн үнэт зүйлсийг дэлхий дахинд сурталчлан таниулах онцгой үүрэгтэй гэж үздэг. Иймээс үндэсний өв соёл, ардын урлаг, утга зохиол, үндэсний спорт, байгаль орчин, аялал жуулчлалын давуу талуудыг олон улсын үзэгч, сонсогчдод хүргэх чанартай контент үйлдвэрлэлийг бодлогоор дэмжихэд анхаарч орчин үеийн дижитал технологи, хиймэл оюун ухаан, олон улсын хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааг өргөжүүлэн Монгол Улсын хөгжил дэвшил, ардчилал, боловсрол, шинжлэх ухаан, инновацын ололт амжилтыг дэлхийн улс орнуудад сурталчлах, гадаад хэл дээрх контентын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын хамтарсан нэвтрүүлэг, баримтат кино, танин мэдэхүйн бүтээлүүдийг хөгжүүлэх бодлогыг дэмжин ажиллах болно.

Түүнчлэн хилийн чанад дахь монгол иргэд, монгол судлаачид болон Монгол Улсыг сонирхогч гадаадын үзэгчдэд зориулсан мэдээллийн сувгийг өргөжүүлж, Монголын өв соёл, аялал жуулчлал, хөрөнгө оруулалт, бизнесийн боломжуудыг

дэлхий нийтэд таниулах замаар улсын нэр хүнд, зөөлөн хүчний бодлогыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах явдал юм.

Цаашид боловсрол, соёл, урлагийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах уран бүтээлийн бүх хэлбэрийг дэмжих, хувь хүн болон нийгмийн хөгжлийг дэмжих бодлого боловсруулахад санаачилгатай гаргах, ялангуяа хүүхэд, залуучуудын боловсрол, гэр бүлийн хүмүүжил, үндэсний үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хиймэл оюун ухаан болон орчин үеийн технологийн мэдлэгийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд онцгойлон анхаарна.

Олон нийтийн радио, телевиз нь үйл ажиллагаандаа хараат бус байх, бодит мэдээлэл түгээх, иргэний эрхийг хүндэтгэх, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, улс төрийн нам, албан тушаалтан, аж ахуйн нэгж, хувь хүний бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг тууштай баримтлах ёстой гэж үздэг.

Мөн улс төр, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, үндэсний болон нийтийн спорт зэрэг нийгмийн амьдралын олон салбарыг хамарсан чанартай хөтөлбөрүүдийг хөгжүүлэх, сонсогч, үзэгчдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгох, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид нийцсэн санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, хөтөлбөрийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр идэвх санаачилгатай ажиллана.

Олон нийтийн радио, телевиз нь зөвхөн мэдээлэл түгээх байгууллага бус Монгол Улсын үнэт зүйлс, соёлын өв, оюуны баялаг, хөгжлийн ололтыг дэлхийд таниулах үндэсний индэр байх ёстой. Энэхүү эрхэм зорилгын хүрээнд Үндэсний зөвлөлийн гишүүний хувиар иргэдийн эрх ашиг, үндэсний үнэт зүйлс, улс орны урт хугацааны хөгжлийн бодлогыг эрхэмлэн ажиллаж, өөрийн мэдлэг, туршлагаа зориулна.

М.Төрманлай нэр дэвшигч:

Миний бие Маналжав овогтой Төрманлай нь Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж буй иргэн хүний хувиар энэхүү албанд нэр дэвших нь ард түмний итгэл хүлээсэн, нийт иргэдийн эрх ашгийг төлөөлөх, хариуцлагатай үүрэг болохыг бүрэн ухамсарлаж байна.

Сэтгүүлзүй, хэвлэл мэдээлэл, дэлгэцийн урлагийн салбарт би 20 гаруй жилийн турш тасралтгүй ажиллахдаа Монголын телевизийн салбарын мэргэжлийн стандартыг шинэ шатанд гаргах, “Хөгжлийн сэтгүүлзүй” зэрэг шинэ чиг хандлагыг төлөвшүүлэх, нийгмийн сэтгэл зүйд эерэг нөлөө үзүүлэх уран бүтээлийг туурвих зэрэг чиглэлээр бодитой хувь нэмэр оруулсан. Миний ажил амьдралын туршлага, мэргэжлийн мэдлэг чадвар, нийгмийн хариуцлагатай хандлага нь олон нийтийн мэдээллийн байгууллагын хараат бус, ил тод, шударга үйл ажиллагааг дэмжих, ардчилсан үнэт зүйлсийг сахин хамгаалахад чиглэгдэнэ.

Үндэсний зөвлөлийн гишүүнээр ажиллахдаа би дараах зарчмыг тууштай баримтлана. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллах;

- Олон нийтийн радио, телевизийн хараат бус байдал, мэргэжлийн ёс зүй, бодит мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад хяналт тавих;
- Улс төр, бизнесийн нөлөөллөөс ангид, олон ургальч үзэл, олон нийтийн төлөөллийн зарчимд нийцсэн бодлогыг дэмжих;
- Үндэсний соёл, уламжлал, хэл, түүхийг дээдэлж, нийгмийн эмзэг бүлгийн мэдээллийн хүртээмжийг сайжруулахад хувь нэмэр оруулах;
- Хөтөлбөрийн бодлого, агуулгын чанар, хүртээмж, оролцоог хянаж, олон нийтийн саналыг тусгасан ухаалаг шийдвэр гаргах болно.

Мөн энэхүү албан тушаалд нэр дэвших хууль зүйн шаардлагуудыг (ял шийтгэлгүй байх, улс төрийн болон төрийн албан хаагч биш байх, радио, телевизийн хөрөнгө оруулалттай этгээд бус байх зэрэг) бүрэн хангаж буйгаа албан ёсоор мэдэгдэж байна. Би Монголын олон нийтийн эрх ашгийг дээдэлсэн, ил тод, шударга, мэргэжлийн, хариуцлагатай мэдээллийн орчныг бүрдүүлэхийн төлөө тууштай ажиллах болно.

Г.Энхбаяр нэр дэвшигч:

Миний бие МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлд дараах үндэслэлд тулгуурлан нэр дэвшсэн болно. Үүнд:

Бакалаврын суурь мэргэжил маань Кино, телевизийн эдийн засагч бөгөөд төгсч ирээд монгол кино нэгтгэлд зургийн даргаар ажиллаж Халх голын дайны цуврал баримт кинонууд, Цагаан морьт баатар, дархан цаазат ховор ан амьтны цуврал баримтат кино, Цам зэрэг 10 гаран баримтат кинонд ажиллаж уран бүтээл хэрхэн яаж бүтдэг туршлагыг хуримтлуулсан билээ. Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийн бүх цаг үе дэх ажлын хэсэгт ажилласан.(3 ажлын хэсэг томилогдож байв.) Энэхүү хууль батлагдсанаар телевизийн киноны уран бүтээлчидэд ч ач холбогдол бүхий болсон юм. Үндсэн мэргэжлийн хувьд кино ба телевизийн хөгжлийн асуудалд ямагт анхаарал хандуулж ирсэн бөгөөд 1917 онд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Олон нийтийн телевизийн хөгжлийн чиг хандлага” олон улсын хуралд оролцсон, 2024 онд Кино урлагийн салбарын уран бүтээлчдийн улсын зөвлөгөөнд “Киноны салбарын хүний нөөцийг чадавхжуулах нь” илтгэл тавьж хэлэлцүүлээ.

Боловсролын салбарт 28 жил багш, тэнхмийн эрхлэгч, хөтөлбөрийн удирдагчаар ажилласан. Монголын багш нарын холбоо НҮТББ нь сүүлийн жилүүдэд ажил мэргэжлийн хувьд боловсролын салбарыг төлөөлөх төлөөлөлгүй байгаа Үндэсний зөвлөлд салбараа төлөөлөх итгэл хүлээлгэн шийдвэр гаргаж нэр дэвшүүлээ. Олон нийтийн радио, телевиз нь хуульд тодорхойлсон зорилгынхоо хүрээнд сонсогч, үзэгчдэд зориулсан сургалт, танин мэдэхүйн нэвтрүүлгийг олон нийтэд хүргэх төдийгүй боловсролын зарим тулгамдсан асуудлаар олон нийтийн санаа бодолд тулгуурласан, мэргэжлийн түвшний судалгаатай, сайн нэвтрүүлэг бэлтгэж бодлого боловруулагчидын анхааралд хүргэх гүүр байхад боловсролын салбарын төлөөллийн хувьд анхааран ажиллана.

Олон нийтийн радио телевиз нь улсын төсвийн дэмжлэг, радио телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хураамжаас сүүлийн жилүүдийн дунджаар 18 тэрбум орчим орлоготой ажиллаж байгаа бөгөөд үүнийг хөгжлийн бодлогын санхүүжилт гэж харах замаар стратегийн эрэмбэлэлттэй төлөвлөлт хийж хөгжлийн бодлого ба санхүүгийн менежмент хоёрыг уялдуулах нь чухал юм. Олон нийтийн радио,

телевизийн тухай хуулийн дагуу Үндэсний зөвлөлийн хүлээсэн чиг үүрэг тухайлбал, үйл ажиллагааны үндсэн зорилт, стратеги төлөвлөгөө, тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт мэргэшлийн бэлтгэлийн хувьд идэвхтэй оролцоотой байх боломжтой гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд МҮОНРТ-ийн ҮЗ-ийн дэргэдэх орон тооны бус хяналтын зөвлөлд 8 жил ажиллаж байна. Хяналтын зөвлөлийн чиг үүргийн дагуу Үндэсний зөвлөлөөр хэлэлцэх бүх асуудалд хурлын өмнө дүгнэлт гаргадаг бөгөөд энэ хугацаанд 80 гаран дүгнэлт зөвлөмж боловсруулан гаргасан байна. Ерөнхий дүгнэлт хийхэд төлөвлөлт, хүний нөөцийн удирдлага, санхүүгийн удирдлагад сул тал ажиглагддаг тул хүний нөөцийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох, бүртгэлийн бодлогын баримт бичиг зэргийг шинэчлэн боловсруулахад биечлэн оролцсон. Өөрийн санаачлагаар гүйцэтгэх удирдлага, продюсерууд, дунд шатны менежерүүдийг хамруулан 2022 оны 11 сард “Төсөл хөтөлбөрийн эдийн засгийн шинжилгээний арга зүй”-н сургалт хийсэн. Цаашид хүний нөөцийн чанарын дутмагшилд орох эрсдэл ч магадлалтай юм. 2022 онд Maxima судалгааны байгууллагын гүйцэтгэсэн “МҮОНРТ-ийн үндэсний хэмжээний нэр нөлөө, иргэдийн итгэл хүлээсэн байдлын судалгаа”-ны чанартай, хараат бус мэдээллийн хэрэгсэл мөн эсэх асуулгад сөрөг үнэлгээ давамгайл байсан ба дийлэнх асуулгад мэдэхгүй гэсэн хариулт зонхилж байсан нь хандалт буурч байгаагийн илрэл байсан. Г.Энхбаяр миний бие МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлд сонгогдвол хүний нөөцийн удирдлага, ялангуяа залуу уран бүтээлч, сэтгүүлчид мөн техникийн ажилтнуудыг улам бүр мэргэшүүлж чанаржуулах бодлогод гүйцэтгэх удирдлагад зөвлөн тусалж ажиллах болно.

Л.Энхжин нэр дэвшигч:

Миний бие нь 1998 онд Радио телевизийн дээд сургуулийг Радио телевизийн найруулагч мэргэжлээр төгссөн цагаас эхлэн телевизийн салбарт тасралтгүй 27 ажиллаж байна. Миний ажлын гараагаа анх эхлүүлсэн газар бол яах аргагүй өнөөдрийн МҮОНРТ билээ. Уг байгууллагын тухайн үеийн өнгө төрхийг тодорхойлж явсан олон арван гайхамшигт уран бүтээлчидтэй мөр зэрэгцэн ажиллаж үнэт алтан сургаалиас нь өөрийн чадах хэмжээгээр тусган авч уран бүтээл, ажил хөдөлмөртөө мөрдлөг болгон явдаг юм. Түүнчлэн 2000 оны эхэн үеэс тухайн цаг үед цоо шинэ өнгө төрх болж байсан хэд хэдэн арилжааны телевизэд орж өөрийн ур чадвараа нэмэгдүүлэн, ард иргэдийн мэдэх эрхийг хангахын төлөө хичээн ажилласаар ирсэн.

Мөн өөрийн хүсэл сонирхолын үүднээс Монголын өв уламжлал, ёс заншил, түүх, нүүдэлчин ахуй соёлын талаар судлан сурвалжилж, хүсэл сонирхол, үзэл санаа нэгтэй олон сайхан уран бүтээлчид, судлаачидтай хамтран “Монгол гайхамшиг” төв хэмээх ТББ-ыг үүсгэн байгуулалцаж гүйцэтгэх захирал, тэргүүнээр нь ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд МҮОНРТ-дээ өөрийн үндсэн мэргэжил болох найруулагчийн ажлыг үргэлжлүүлэн хийсээр ирлээ. 2020 оноос МҮОНРТ-ийн ерөнхий найруулагчаар ажиллаж байх үед дэлхийг хамарсан цар тахлын хүнд үе таарсан бөгөөд тухайн цаг үед уран бүтээлчдын хувьд үзэл бодлын зөрүүтэй байдлаас шалтгаалан зөрчилдөх, үл ойлголцол гарч байсан нь тус байгууллагын удирдах дээд зөвлөлд яг тухайн байгууллагатаа ажиллаж байгаа, эгэл жилийн уран бүтээлчдийнхээ жаргал зовлонг сайн мэддэг хүн зайлашгүй байх ёстой юм байна гэж ойлгогдсон.

Мөн Олон нийтийн радио телевизийн хуулинд өөрчлөлт оруулан сайжруулах, үзэгч түмэнд чанартай сайн уран бүтээл хүргэхийн тулд байгууллагын санхүү, хууль эрх зүйн орчинг сайжруулах, уран бүтээлчдийн нийгмийн хангамж, ажлын орчин нөхцөлийг сайжруулах, орчин үеийн дэвшилдэт техник технологи нэвтрүүлэх гээд олон тулгамдсан асуудлууд байдаг. Энэ бүхэнд өөрийн болон мөр зэрэгцэн ажилладаг олон арван уран бүтээлчдын дуу хоолой болж ажиллах сонирхолтой байна. Тус байгууллагын Үндэсний зөвлөлд мэргэжлийн уран бүтээлчийн орон зай үгүйлэгдэж байгаа учир өөрийн нэрийг дэвшүүлж байгаа билээ.

Б.Энэрэлт нэр дэвшигч:

Олон нийтийн радио телевизийн хуулийн дагуу Монголын ард түмний төлөө үйлчилж олон нийтийн радио телевиз түүний зарчмыг хэрэгжүүлэхийн төлөө өөрийн мэдлэг боловсрол тулгуурлан ашиг сонирхлын ангид хараат бус зарчмаар ажиллах болно.

Өнөөгийн дижитал платформуудын эрчимтэй өрсөлдөөний нөхцөлд залуу үзэгчдийн анхаарлыг татах, мэдээллийн үнэн зөв байдлыг хамгаалах, олон нийтийн итгэлийг тасралтгүй бэхжүүлэх нь хамгийн чухал сорилтын нэг. Ийм нөхцөлд олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага нь мэргэжлийн ёс зүй, бодит мэдээлэл, нийгмийн хариуцлагын үнэт зүйлсийг тууштай хадгалж ажиллах шаардлагатай гэж бодож байна.

Миний ажилласан салбаруудын нийтлэг үндэс нь хараат бус, хариуцлагатай шийдвэр гаргалт байсан. Хэрэв миний бие энэхүү албан тушаалд томилогдвол хууль тогтоомж, байгууллагын эрх ашиг, олон нийтийн итгэлд тулгуурласан шийдвэр гаргах зарчмыг баримталж, аливаа улс төрийн болон бизнесийн нөлөөллөөс ангид ажиллахыг эрхэмлэнэ.

Түүнчлэн байгууллагын төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авалт, дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог олон улсын сайн туршлагад нийцүүлэн хөгжүүлэхэд өөрийн туршлага, мэдлэгээр хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна.

Цаашид зөвхөн мэдээлэл түгээхээс гадна үндэсний өв соёл, боловсрол, шинжлэх ухаан, баримтат болон олон нийтийн үнэ цэн бүхий контентыг дэмжих замаар Монгол Улсын иргэдийн нийтлэг үнэт зүйл, соёлын дархлааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байна.

7/Нэр дэвшигчидтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Э.Болормаа, А.Ганбаатар, Ж.Золжаргал, Ч.Ундрам, Ө.Шижир нар асуулт асууж, хариулт авсан болно. Тухайлбал:

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар: спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаас нэр дэвшсэн боловч мэргэжил, боловсрол, ажлын туршлага тань үндсэндээ санхүүгийн салбарт төвлөрсөн байна. Энэ нөхцөлд спортын салбарын төлөөллийн үүргийг Үндэсний зөвлөлд хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх талаар;

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа: Нэр дэвшигч Ч.Батцэнгэлийн холбогдсон байж болох ёс зүйн шинж чанартай асуудалд дүн шинжилгээ хийж шалгасан эсэх, судалж үзэж болох талаар;

Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар: Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн контентын чанар, санхүүгийн үр ашиг, редакцын хараат бус байдал, дотоод удирдлагын аль асуудлыг хамгийн их доголдолтой гэж үзэж байгаа, түүнийг хэрхэн шийдвэрлэж, байгууллагад ямар бодит өөрчлөлт, хувь нэмэр оруулахаар төлөвлөж байгаа талаар, мөн Монголын үндэсний олон нийтийн телевизийн үндсэн чиг үүрэг болох ард иргэдийг соён гэгээрүүлэх агуулгыг хөгжүүлэх, дотоодын контент үйлдвэрлэгчидтэй үр ашигтай хамтран ажиллах, редакцын хараат бус байдлыг бэхжүүлэх, хамт олны эв нэгдлийг хангах, гадаад томилолтын үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр хэрхэн ажиллах талаар;

Мөн хууль, эрх зүйн орчныг сайжруулах талаар санаачлагатай ажиллах, хураамж, татаас, санхүүжилтийн зарцуулалтын тухай, ММ агентлагийг улс төрөөс хараат бус байлгах, МҮОНРТ-ийн байранд уран бүтээлийн нэгдлүүдийг хямд өртгөөр байршуулж болох эсэх талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал: залуучуудын дунд шинжлэх ухаан, танин мэдэхүй, шинэ техник технологийн дэлхийн шинэ ололтын талаар соён гэгээрүүлэх ямар бодлого байр суурь баримтлах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам: Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байгаа талаар болон цаашид баримтлах ёстой хөгжлийн чиглэлийн талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир: Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилогдсон тохиолдолд өрхөөс төвлөрүүлдэг санхүүжилтийн ил тод, үр ашигтай зарцуулахын тулд байгууллагын менежментийг хэрхэн шинэчлэх, мөн сонгон шалгаруулалтын баримт бичгийн 500–1000 үгийн шаардлагыг хангаагүй байгаа талаар, ажлын намтарт төрийн өмчит компани болон хувийн банканд ажилласан хугацаа давхцаж байгаа нь ямар үндэслэлтэй талаар асуулт асуусан.

Улсын Их Хурлын гишүүдийн асуултад нэр дэвшигч Д.Гүн-Үйлс, Ч.Батцэнгэл, Ж.Билэгсайхан, Д.Мягмарсүрэн, Д.Наранцэцэг, С.Од-Эрдэнэ, М.Төрманлай, Г.Энхбаяр, Л.Энхжин, Б.Энэрэлт нар хариулт өгсөн болно.

Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь:

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэгт “Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид; эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд; эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно.” гэж, 21.7 дахь хэсэгт “... төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж, 21.8 дахь хэсэгт “... нэр дэвшсэн

хүмүүсийг Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонголт хийсний үндсэн дээр хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129-132 дугаар зүйлийг баримтлан Нэр дэвшигчийн сонголыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 14 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр сонголт оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонголын тайланг гаргалаа.

Хаалттай хурлын тайлан:

Монголын үндэсний олон нийтийн телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдтэй хийсэн нэр дэвшигчийн томилгооны сонголын тайланг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулахыг сонголт оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

**СОНГОЛ ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

СЗУЛПХАР



The image shows a handwritten signature in black ink over a red rectangular official stamp. The stamp contains the text 'МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БЭЙНГҮН ХОРООНД' (State Election Commission of Mongolia) and the identification numbers 'ТҮС3764 9023051393 9087184'.